


ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


2025 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

1. Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Арга хэмжээ 3.10.20 Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд:
 - ❖ Газрын даргаар 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр 17 заалт бүхий Хот байгуулалт, хотын стандартын газрын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 17 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллав. /100%/
2. Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Арга хэмжээ 3.10.21 Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлагын дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлэх ажлын хүрээнд:
 - ❖ Газрын даргын 2025 оны А/24 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах үүргийг дэд хорооны нарийн бичгийн даргад хүлээлгэсний дагуу дэд хорооны 2025 оны I дүгээр хурлаар бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар хэлэлцэн, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.8-ыг үндэслэн албан хаагчдын дунд цахимаар болон цаасаар санал хураалтыг явуулж Захиргаа, удирдлагын хэлтэст саналыг хүргүүлснээр газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/26 дугаар тушаалаар бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэйгээр шинэчлэн баталсан.
 - ❖ Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.6-г үндэслэн Дэд хорооны даргаар Н.Дарханбаяр, гишүүд О.Ганхуяг, Б.Батбилэг, Ж.Халиун, Б.Биндэръяа, У.Уянга нарийн бичгийн даргаар Д.Уранбайгаль нарыг сонгогдон тайлант хугацаанд ажиллалаа.
3. Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах ажлын хүрээнд:
 - ❖ Байгууллагын мэдээллийн цагаар 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “С.Молор-эрдэнэ Философийн академи”-н тэргүүн, лектор С.Молор-эрдэнийн “Танин мэдэхүй-ёс зүй-гоо зүй” сэдвээр хувь хүний ёс зүй, харилцаа хандлага, байгууллагын соёл, ухамсрын талаарх мэдлэгийг албан хаагчдад таниулж, соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулсан.
4. Сургалт, нөлөөллийн арга хэмжээ:
 - ❖ Байгууллагын албан хаагчдын Viber дотоод сүлжээнд МУ-ын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоол Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, албан хаагчдын компьютерийн дэлгэцэнд Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн хэм хэмжээг сарын хугацаанд байршуулж сурталчлан таниулах арга хэмжээг авч ажилласан.




- ❖ Байгууллагын соёл, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд НЗДТГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 03/2617 дугаартай албан бичгээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолын хүрээнд төрийн албан хаагч нь ажлын байранд ажлын цагаар албаны хувцаслалттай байх талаар анхаарч ажиллах тухай ирүүлсэн. Уг ажлын хүрээнд байгууллагын өрөө бүрт орж, албан хаагчдыг өдөр тутмын албаны хувцаслалттай байх, иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ харилцаа, хандлагаа сайжруулах, үг үйлдлээрээ бусдад үлгэрлэл үзүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, анхааруулж ажилласан. Мөн цаашид долоо хоног бүрийн Даваа гаригт цагаан цамц өмсөж хэвших дадлыг суулгах байгууллагын соёлд уриалан ажиллаж байна.
- ❖ Шинээр томилогдсон 15 албан хаагчдад Төрийн албаны хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, МУ-ын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоол Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг батлах тухай, 2020 оны 246 дугаар тогтоол Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, НЗД-ын 2022 оны А/1049 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам, НЗД-ын 2024 оны А/478 дугаар захирамж Байгууллагын дүрэм, Нэгжийн дүрэм, албан тушаалын тодорхойлолт, бусад холбогдох эрх зүйн актуудтай танилцсан баталгааны маягт дээр гарын үсгээр баталгаажуулж авсан.



- ❖ Албан хаагчдын дунд **2025 оны 05 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд** байгууллагын ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, авлига, ашиг сонирхлоос ангид байх сэдвүүдээр ерөнхий мэдлэг шалгах 5 асуулгыг боловсруулж, нийт **69** албан хаагч оролцсоноос **57% нь** зөв хариулсан ба цаашид албан хаагчдын дунд дараах 2 төрлөөр сургалт зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх шаардлагатай дүгнэлтийг газрын даргад танилцуулсан.

АЛБАН ХААГЧДЫН 70% ЕРӨНХИЙ МЭДЛЭГ ШАЛГАХ СУДАЛГААНД ХАМРАГДЛАА				
№	Асуулт	Хамрагдсан албан хаагчийн тоо	Зөв хариулсан албан хаагч	
			тоо	хувь
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэдэн онд батлагдсан бэ?	69	46	66.7
2	Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэхдээ ямар зүйлд тулгуурладаг вэ?	69	46	66.7
3	Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах гэдгийг Авлигын эсрэг хуульд хэрхэн тодорхойлсон бэ?	69	36	52.2
4	Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг хэрхэн хамгаалах вэ?	69	26	37.7
5	Өргөдөл, гомдлын хянан үзэхгүй байх, буцаах нөхцөлд аль нь хамаарахгүй вэ?	69	40	58
Дүгнэлт: Дээрх судалгааны нэгдсэн дүнгээр байгууллагын албан хаагчдад 2 төрлийн сургалтыг зохион байгуулж авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.				


- ❖ Газрын даргад танилцуулсны дагуу Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн чиглэлээр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс **2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр** нийт албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан.



- ❖ НЗДТГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 03/2617 дугаартай албан бичгээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024оны 10 дугаар сарын

02-ны өдрийн 109 дүгээр тогтоолын хүрээнд төрийн албан хаагч нь ажлын байранд ажлын цагаар албаны хувцаслалттай байх талаар анхаарч ажиллах тухай ирүүлсэн. Уг ажлын хүрээнд байгууллагын өрөө бүрт орж, албан хаагчдыг өдөр тутмын албаны хувцаслалттай байх, иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ харилцаа, хандлагаа сайжруулах, үг үйлдлээрээ бусдад үлгэрлэл үзүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, анхааруулж ажилласан. Мөн цаашид долоо хоног бүрийн Даваа гаригт цагаан цамц өмсөж хэвших дадлыг суулгах байгууллагын соёлд уриалан ажиллаж байна.

- ❖ “БИД ИРГЭДЭЭ СОНСОЖ, ШИЙДНЭ” аяны хүрээнд Газрын Хэрэглэгчийн үнэлгээ хийх судалгааны багийн бүрэлдэхүүн болон Чанарын багтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийн хооронд газрын үйлчилгээ авч байгаа 45 иргэдээс цаасаар болон цахим хуудсаар “Сэтгэл ханамжийн судалгаа” авч ажилласан бөгөөд судалгааны дүгнэлтийг үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хэрэглэгчийн үнэлгээ хийх судалгааны багийн бүрэлдэхүүн болон Чанарын багтай хамтран боловсруулж, газрын даргад танилцуулсан.



- ❖ Яармаг дахь Нутгийн захиргааны Б блокын 10 давхарт байрлах байгууллагын мэдээллийн самбарт ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД буланд санал хүсэлтийн хайрцаг, авлигын эсрэг үйл ажиллагаа мэдээллүүдийг байрлуулж ажиллаж байна.
- ❖ Ёс зүйн хорооноос 11 дүгээр сарыг “Хүндэлье-Энэрье” ёс зүйн нөлөөллийн сар болгон зарласантай холбогдуулан газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/63 дугаартай тушаалаар Залуучуудын зөвлөл, Захиргаа, удирдлагын хэлтэстэй хамтран Танин мэдэхүйн Quiz /АХА/ тэмцээнийг зохион байгуулж хот байгуулалттай холбоотой 2, авлига, ёс зүйтэй холбоотой 5 нийт 7 асуулт, хариултын материалыг боловсруулан сургалт, нөлөөллийн ажлыг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа.

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 01 өдөр Дугаар 4/63 Улаанбаатар хот

Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах тухай



Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, "Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн хорооноос 11 дүгээр сарыг "Хүндэлэе – Энэрлэе" ёс зүйн нөлөөллийн сар болгон зарласантай холбогдуулан байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын дунд Үндсэн хуулийн түүхэн ач холбогдол, Үндсэн хууль төрийн байгуулал, хууль ёсоо эрхэмлэн дээдлэх үзэл санааг таниулах, үндэсний үнэт зүйлдээ хандах мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн манлайллыг төлөвшүүлж, итгэл төрүүлэх төрийн үйлчилгээг бий болгох соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсугай.


2. Сургалт, нөлөөллийн арга хэмжээний нийт зардал 1,200,000 (нэг сая хоёр зуу) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Лхам)-д зөвшөөрсүгэй.

3. Сургалт, нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Н.Дарханбаяр), Залуучуудын хөгжлийн зөвлөл (М.Амарзаяа), Захиргаа, удирдлагын хэлтэс (Д.Дашцэцэг)-т нарт тус тус даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭГЭЙН
Г.БАЯРСАЙХАН



5. Авлигатай холбоотой дүрэм журамд санал өгөх, зөвлөмжийг дагаж мөрдөх, хэрэгжилтийг тайлагнах ажлын хүрээнд:
- ❖ Байгууллагын www.uds.ub.gov.mn цахим хуудсанд ТАНЫ ЭРХ, ТАНЫ ОРОЛЦОО, АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЬЕ зөвлөмжийг байршуулж, албан өрөөнүүдэд АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ, 110 зурагт хуудсуудыг байршуулж, зөвлөмжийг мөрдөж ажиллаж байна.
6. Байгууллагын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сувгаар ёс зүйн мэдээ, мэдээллийг тогтмол байршуулах ажлын хүрээнд:
- ❖ www.uds.ub.gov.mn байгууллагын цахим хуудасны мэдээ мэдээлэл буланд Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг байршуулсан.



- ❖ Байгууллагын www.uds.ub.gov.mn цахим хуудсанд ТАНЫ ЭРХ, ТАНЫ ОРОЛЦОО, АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЬЕ зөвлөмжийг байршуулж, албан өрөөнүүдэд АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ, 110 зурагт хуудсуудыг байршуулж, зөвлөмжийг мөрдөж ажиллаж байна.



7. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, батлуулах ажлын хүрээнд:

- ❖ Газрын ёс зүйн дүрмийг Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-г үндэслэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухай тушаалын төслийг боловсруулсан.
- 8. Албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг цаасан болон цахимаар хүлээн авах, шийдвэрлэх асуудлаар:
- ❖ Тайлант хугацаанд тус газарт хаяглаж Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн G250730061 дугаартай иргэн Ц.З-ийн гомдлоор ХУД-ийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй барилгын ажлын талаар тус газрын Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Н.М нь худал мэдээлэл тарааж, иргэдээр олон нийтийн сүлжээ, мэдээний сайтад хэлүүлж байгаа тухай ирүүлснийг Захиргаа, удирдлагын хэлтсээс 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдөр газрын ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцүүлэхээр гомдлыг шилжүүлж ирүүлсэн. Гомдол гаргагч нь тухайн барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд мөн эсэх баримтаа ирүүлээгүй нь “ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ”-ийн 10 дугаар зүйл. “Өргөдөл, гомдолд тавих шаардлага”-ийн 2 дахь хэсэгт “Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримтыг ирүүлээгүй, Гомдолд холбогдогч албан хаагч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16 дахь хэсэгт заасанчлан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй” гэх эрхийн дагуу уг гомдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, 8 дугаар зүйлд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн зөрчил гаргаагүй гэж Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн үзэж Ёс зүйн дэд хорооны 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн №1 дугаартай “Ёс зүйн зөрчил гаргаагүй тухай” дүгнэлтээр баталгаажуулсан.

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

2025 оны 08 сарын 29 өдөр Дугаар 1 Улаанбаатар хот

ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ ГАРГААГҮЙ ТУХАЙ

Ёс зүйн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх журамд тус дэд хорооны дарга Н.Дарханбаатар дарга, гишүүн У.Уянга, Б.Биндэръяа, О.Ганхууг, Ж.Халиун, нарийн бичгийн дарга Д.Уранбайгаль, гомдоллогч хамтлагч нарын бүрэлдэхүүнтэй, гомдол гаргагч Иргэн Ц.Зас-Эрдэнэс Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн дагуул хот, адийн засгийн тусгай бүсийн төлөөлөлт хариуцсан мэргэжилтэн Н.Мадгадбадам Ёс зүйн зөрчил гаргасан гомдлыг 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч, хяналт шалгалтыг явуулж Хот байгуулалт, хотын стандартын газрын 1020 тоот танхимд нарийн бичгийн даргын тангидуулснаар нээлттэй хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь
Ц.Зас-Эрдэнэс “ХУД-ийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй “Сидар сити” хотын барилгын талаар Н.Мадгадбадам нь худал мэдээлэл тарааж, иргэдээр худал мэдээлэл олон нийтийн сүлжээ, мэдээний сайтад хэлүүлж байгаа гомдолтой байна. Би өөрөө төрийн албан хаагч тул яриа өгч болохгүй, яриа өгөх 2-3 хүнд хэлэх үгийг нь бэлдэж өгөн, нотлох баримт нь байгаа гэх мэдээлэл бидэнд байгаа гэсэн тухай ирүүлсэн” гэх гомдол, мэдээллийг гаргажээ

ҮНДЭСЛЭХ нь
Ёс зүйн дэд хорооны гишүүн Ж.Халиун: “Монгол Улсын Үндсэн хуулийн Арав зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт заасанчлан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх” гэж заасны дагуу иргэний хувьд өөрийн өмч хөрөнгөө хамгаалах эрхээ эдэлсэн гэж ойлгож байна.
Ёс зүйн дэд хорооны гишүүн У.Уянга: Иргэн Ц.Зас-Эрдэнэс нь “Талст ширээт” ХХК-ийг төлөөлөх эрх бүхий этгээд мөн эсэх нь тодорхойгүй байна. “ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ” ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ”-ийн 10 дугаар зүйл. “Өргөдөл, гомдолд тавих шаардлага”-ийн 2 дахь хэсэгт “Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана” гэж заасан байна. Үүний дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгч гэдгээ батлах баримт бичгийг ирүүлээгүй

Гомдолд холбогдогч Н.Мадгадбадам нь өөрийн биеэр журамд оролцох боломжгүй тул утсаар тайлбар авахад “өөрийн өмч хөрөнгөө хамгаалахын тулд тухайн барилгын зөвшөөрлийг гаргаа”

Гомдолд холбогдогч Н.Мадгадбадам нь иргэсний амралтаа авсан, иргэсний хөжүүр үзэж ирдого гэх шалтгаанаар зөвлөлт хэвтэж байгаа, мөн төрийн албан хаагчийн хувьд бий иргэний хувьд өөрийн амьдрал буй эрчэнд баригдаж буй барилгын ажлын зөвшөөрлийн талаар үзэл бодлоо илэрхийлсэн гомдол гаргагч иргэн Ц.Зас-Эрдэнэс нь баригдаж буй барилгын компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх баримтыг өргөдөлдөө хавсаргаж ирүүлээгүй тул ёс зүйн зөрчилтэй үйлдэл, эс үйлдэхүй гаргаагүй, нотлогдохгүй байна

Иймд Н.Мадгадбадам нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, 8 дугаар зүйлд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн зөрчил гаргаагүй гэж Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн үзэв.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1, 13.3.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалт, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 6 дугаар зүйлийн 6.10, 6.11, 6.12, 5, 6.16 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ДҮГНЭХ нь


- 1 Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн дагуул хот, адийн засгийн тусгай бүсийн төлөөлөлт хариуцсан мэргэжилтэн Н.Мадгадбадам нь ёс зүйн зөрчил гаргаагүй байна гэж дүгнэв.
- 2 Энэ дүгнэлтийг гомдолд гаргагч, гомдолд холбогдогч болон томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, ёс зүйн зөрчлийн бүртгэл, ик-нэлтийн цахим системд бүртгэж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.Уранбайгальд үүрэг болгов.
- 3 Энэ дүгнэлтийг эс зөвшөөрөл гомдол гаргасан этгээд түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор дээд шатны байгуулалтын Ёс зүйн дэд хороонд гомдол гаргах эрхтэй.

ДАРГА
ГИШҮҮН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.Дарханбаатар
Ж.Халиун
У.Уянга
Б.Биндэръяа
О.Ганхууг
Б.Батбилэг
Д.Уранбайгаль


9. Шилдэг албан хаагчийг шалгаруулах ажлын хүрээнд дэд хорооны 2025 оны 102 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр хурлаар ажлын гүйцэтгэл, цаг ашиглалт, албан хэрэг хөтлөлт, харилцаа, хандлага, хувцаслалт, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн 1 албан хаагчийг шалгаруулан, саналыг үнэлгээний багт хүргүүлэв.
10. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, тайлан мэдээг хагас, бүтэн жилээр тайлагнах, цахим хуудсанд нээлттэй байршуулах ажлын хүрээнд:
 - ❖ Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хагас жил, III дугаар улирлын байдлаар гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн байгууллагын www.uds.ub.gov.mn цахим хуудасны Мэдээ, мэдээлэл буланд Хот байгуулалт, хотын стандартын газрын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг, Ил тод байдал цэсний Ёс зүйн буланд Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлтийг байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.
 - ❖ Нийслэл Засаг даргын Тамгын газарт Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт"-ын дагуу 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөрт, байгууллагын Захиргаа, удирдлагын хэлтэст хагас, бүтэн жилийн биелэлтийг хүргүүлж ажиллав.
11. Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах, МУ-ын Ёс зүйн хороо, Удирдлагын академийн багц сургалтад хамруулах ажлын хүрээнд:
 - ❖ МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал зөвлөгөөнд нарийн бичгийн дарга Д.Уранбайгаль, гишүүн Б.Биндэръяа нар 2025 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд оролцож, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэгт нийслэлийн 6 байгууллагатай хамтран өгөгдсөн жишээ тохиолдол дээр ёс зүйн дэд хорооны ажиллах үйл ажиллагааны зураглалыг гаргаж, шийдвэрлэлтийг МУ-ын ёс зүйн хорооны гишүүнд тайлагнаж, зөвлөмж авч оролцсон.



- ❖ 2025 оны 04 дүгээр сарын 28-нд дэд хорооны нарийн бичгийн дарга Д.Уранбайгаль "Авлигаас ангид төрийн алба" анхан шатны цахим сургалтад хамрагдаж сертификат авсан.



- ❖ АТГ, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах “СУРГАГЧ БАГШ” бэлтгэх анхан шатны 2 өдрийн сургалтад дэд хорооны гишүүн Б.Биндэръяа хамрагдсан.



- ❖ МУ-ын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан байгууллагуудын дэд хороодын гишүүдийг чадавхжуулах сургалтанд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр нарийн бичгийн дарга хамрагдаж Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛД ӨРТӨХ ЭРСДЛИЙГ ТООЦОХ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ”, Эрсдлийн үнэлгээний хуудас, Эрсдлийг бууруулах арга хэмжээний хяналтын хуудастай танилцаж мэдээлэл авсан.



2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 1.1.1 дэх заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.1.2.1, 2.1.2.2 дахь заалт, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ыг нэгдүгээр, "Эрсдэлийн үнэлгээний хуудас"-ыг хоёрдугаар, "Эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний хяналтын хуудас"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан аргачлалыг ашиглан байгууллага, салбарын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийж, дүнг үндэслэн холбогдох арга хэмжээ авахыг бүх шатны төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтанд зөвлөсүгэй.

3. Батлагдсан аргачлалаар үнэлгээг хийж, доор дурдсан ажлыг зохион байгуулж 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Ёс зүйн хорооны Ажлын алба (Н.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг төрийн байгууллага сонгон зохион байгуулж дүнг танилцуулах;

3.2. Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулах бэлтгэл ажлыг зохион байгуулж, тайланг нэгтгэн цаашид авах арга хэмжээний саналын хамт Ёс зүйн хорооны хуралдаанд хэлэлцүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавин ажиллахыг Ёс зүйн хорооны Ажлын алба (Н.Ганбаатар)-д даалгасугай.

Хамрах хүрээ	• Байгууллагын нийт албан хаагч
Үнэлгээний хэлбэр	• Төрийн албан хаагчаас бүрдсэн баг (дотоод) • Хөндлөнгийн (эксперт) • Хоолоон
Өгөгдөл цуглуулах арга	• Чанарын (баримт бичиг, ярилцлага) • Тоон (асуулга, судалгаа)
Мэдээллийн эх үүсвэр	• Зөвлөмж, албан даалгавар, судалгаа • Өргөдөл, гомдол, хяналт, аудитын дүн • Ёс зүйн тайлан, хэрэгтэсчийн үнэлгээ • Олон нийтийн сүлжээний мэдээлэл
Хариу арга хэмжээ авах	• Эрсдэл бүрийн шалтгаан, үр дагаврыг дүнжих • Тайлан, дүнлэл, зөвлөмж гаргаж ТЗБАТ-д өгөх • Давтамж өндөртэй эрсдэлд шуурхай арга хэмжээ авах • Дүнд эрсдэлд хяналтын механизмыг боловсронгуй болгох • Бага эрсдэлд мониторинг хийх

Эрсдэл	Тайлбар	Өнгө	Хариу арга хэмжээний хувилбарууд
IV	1-5	Бага эрсдэл	Хяналтыг ургамжлууна Шүүс арга хэмжээ шаардлагатай
III	6-10	Дунд зэргийн эрсдэл	Нэмэлт саналт шаардлагатай Хяналтын арга хэмжээ авах шаардлагатай
II	11-15	Өндөр эрсдэл	Эрсдэлийн бууруулах бодлого, арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай
I	16-20	Маш өндөр эрсдэл	Эрсдэлтэй нөхцөл байдлыг бүрэн өөрчлөх шаардлагатай

- ❖ Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025.10.16-ны өдрийн 4/224 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.2.1-т төрийн албан дахь ёс зүйн асуудал ба

зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг газрын ёс зүйн дэд хорооны 2025/07, 2025/08 дугаар хурлаар хэлэлцүүлэн, хэрэгжүүлж нэгдсэн тайлан, судалгаа бөглөсөн албан хаагч, иргэдийн гарын үсгийн хамт Монгол улсын Ёс зүйн хороо болон НЗДТГ-т тус тус хүргүүлж ажиллав.

"ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ: ШАЛТГААН, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ" ТАНДАХ СУДАЛГАА-ны тайлан

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 4/224 дугаартай албан бичгээр "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.2.1-т төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа авах гэсэн зөвлөмж дагуу 2025.10.15-2025.10.30-ны өдрүүдэд байгууллагын нийт албан хаагчид болон үйлчилгээ авч буй 62 иргэдийн төлөөлөөс "ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ: ШАЛТГААН, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ" ТАНДАХ СУДАЛГАА-г авах талаар ирүүлсэн.

Хот байгуулалт, хотын стандартын газрын ёс зүйн дэд хорооны 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 2025/07 дугаар хурлаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу судалгаа авах ажлыг гишүүдэд уяварилан зохион байгуулах, 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 2025/08 дугаарт хурлаар нэгдсэн тайланг хэлэлцэж нийт 2 удаа хуралдан тайлан, биеэлэлтийг Монгол улсын Ёс зүйн хороо болон НЗДТГ-т тус тус хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

- ✓ Судалгааг олон нийтэд 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР гэсэн facebook хуудас Хан-Уул дүүргийн Яармаг дахь Нутгийн захиргааны 5 блок байрны 1 давхрын иргэдэд үйлчлэх төвөөр үйлчлүүлж буй иргэдэд QR бүхий судалгааг байршуулан судалгааны ач холбогдол, бусад ерөнхий мэдээлэл, зөвлөмжөөг ач иргэдэд үйлчлэх төвөөр 62 иргэнийг судалгаанд хамруулан гарын үсгээр баталгаажуулж авсан ба 3 иргэн байгууллагын facebook хуудсанд хандан нийт 66 иргэнээс судалгааг авсан.
- ✓ Байгууллагын албан хаагчдын дотоод сүлжээ болон гар утасны viber группт 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр судалгааны талаар мэдээлэл, зөвлөмжийг хүргүүлэн, нэгжийн дарга, ахлахууд хяналт тавьж, нийт 69 албан хаагчаар судалгааг бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулж авсан.

Хавсралт: Ёс зүйн дэд хорооны 2025/07, 2025/08 дугаар хурлын тэмдэглэл-2 хуудас, 62 иргэний судалгаа бөглөсөн гарын үсэг бүхий жагсаалт-2 хуудас, 69 албан хаагчийн судалгаа бөглөсөн гарын үсэг бүхий жагсаалт-5 хуудас, нийт 9 хуудастай.

Хянасан:  Н.Даринбаяр
(Хот байгуулалт, хотын стандартын газрын Ёс зүйн дэд хорооны дарга)

Тайлан гаргасан:  Д.Уранбайгаль
(Хот байгуулалт, хотын стандартын газрын Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга)

2025 оны 10 дугаар сарын 31 өдөр

Хэрэглэгдэхүүн - Анкет

Төрийн албан хаагч (Анкет)

Иргэд (Анкет)

Төрийн албан хаагчийн судалгааны анкет дараах онцлогийг агуулсан байх ёстой:

- Нууцлал, аюулгүй байдлыг баталгаажуулсан танилцуулгатай байх
- Боловсрол, ажил, хувийн мэдээллийг тусгааргүй байх

- ❖ Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчил: Иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгааны үр дүнг танилцуулах цахим хуралд нарийн бичгийн дарга хамрагдсан.




ХЭРЭГЛЭГДЭХҮҮН - АНКЕТ

Төрийн албан хаагч (Анкет)

Иргэд (Анкет)

Төрийн албан хаагчийн судалгааны анкет дараах онцлогийг агуулсан байх ёстой:

- Нууцлал, аюулгүй байдлыг баталгаажуулсан танилцуулгатай байх
- Боловсрол, ажил, хувийн мэдээллийг тусгааргүй байх



Судалгааны үр дүнгээр танилцуулсан зөвлөмжийг байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН
СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Н.ДАРХАНБАЯР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.УРАНБАЙГАЛЬ



БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО-2025



ᠨᠢᠶᠢᠲᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ
ᠨᠢᠶᠢᠲᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ
ᠨᠢᠶᠢᠲᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ

Төрийн албан
хаагчийн ёс
зүйн тухай
хууль

Төрийн
албаны тухай
хууль

Авлигын эсрэг
хууль

Нийтийн албанд
нийтийн болон хувийг
ашиг сонирхлыг
зохицуулах, ашиг
сонирхлын зөрчлөөс
урьдчилан сэргийлэх
тухай хууль



ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Ёс зүйн дэд хорооны дарга: Хот байгуулалтын хяналтын хэлтсийн дарга **Н.Дарханбаяр**
- Гишүүд: Хот байгуулалтын стандарт хариуцсан мэргэжилтэн **Б.Биндэръяа**
- Гишүүд: Барилгын чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн **О.Ганхуяг**
- Гишүүд: Эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн **Ж.Халиун**
- Гишүүд: Хүний нөөцийн сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн **У.Уянга**
- Гишүүд: Хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн **Б.Батбилэг**
- Нарийн бичгийн дарга: Орон зайн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн **Д.Уранбайгаль**

№	Хурлын огноо	Хуралд оролцсон ирц	Хэлэлцсэн асуудал	Ирц
1	2025.04.07	Ж.Халиун, Б.Батбилэг, Д.Уранбайгаль	Газрын даргын 2025 оны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” А/24 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх	100
2	2025.04.07	Ж.Халиун, Б.Батбилэг, Д.Уранбайгаль, Н.Дарханбаяр, У.Уянга, Б.Биндэръяа, О.Ганхуяг	Газрын дэд хорооны гишүүнээр ажиллуулах хамт олны саналыг хэлэлцэж, газрын даргад танилцуулах	100
3	2025.04.08	Ж.Халиун, Б.Батбилэг, Д.Уранбайгаль, Н.Дарханбаяр, У.Уянга, Б.Биндэръяа, О.Ганхуяг	Газрын дэд хорооны дарга, нарийн бичгийн даргыг сонгож, газрын даргад танилцуулах	100
4	2025.04.16	Ж.Халиун, Б.Батбилэг, Д.Уранбайгаль, Н.Дарханбаяр, У.Уянга, Б.Биндэръяа, О.Ганхуяг	- Дэд хорооны шинэ гишүүдэд хорооны үйл ажиллагаа, өнгөрсөн онд хийсэн ажлын тайланг танилцуулах, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах	100
5	2025.05.13	Ж.Халиун, Б.Батбилэг, Д.Уранбайгаль, Н.Дарханбаяр, У.Уянга, Б.Биндэръяа, О.Ганхуяг	- Сургалт зохион байгуулах - Албан хаагчдын хувцаслалт	100
6	2025.08.29	Ж.Халиун, Д.Уранбайгаль, Н.Дарханбаяр, У.Уянга, Б.Биндэръяа, О.Ганхуяг	Албан хаагчид ирсэн гомдлын талаар	85
7	2025.10.23	Ж.Халиун, Б.Батбилэг, Д.Уранбайгаль, Н.Дарханбаяр, Б.Биндэръяа, О.Ганхуяг	“ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ: ШАЛТГААН, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТАНДАХ СУДАЛГАА” авах ажлыг зохион байгуулах	85
8	2025.10.31	Ж.Халиун, Б.Батбилэг, Д.Уранбайгаль, Н.Дарханбаяр, Б.Биндэръяа, О.Ганхуяг	“ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ: ШАЛТГААН, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТАНДАХ СУДАЛГАА-ны биелэлт	100
9	2025.12.19	Ж.Халиун, Б.Батбилэг, Н.Дарханбаяр, Б.Биндэръяа, У.Уянга	“Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны биелэлтийг хэлэлцэх, - Нийт албан хаагчдаас 2025 оны ажлын гүйцэтгэл, цаг ашиглалт, албан хэрэг хөтөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, харилцаа, хандлага, хувцаслалт, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн 1 албан хаагчийг шалгаруулж, жилийн эцсийн гүйцэтгэлийн үнэлгээний багт саналаа хүргүүлэх	85

ИЛ ТОД БАЙДАЛ

- www.uds.ub.gov.mn цахим хуудсанд Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг байршуулсан
- Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим системд байгууллагын ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, биелэлтийг байршуулсан.
- НЗДТГ-ын ёс зүйн дэд хороонд үйл ажиллагааны биелэлтийг тайлагнаж ажилласан.





БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО-2025







Байгууллагын ёс зүйн дэд хороо

СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

- “Танин мэдэхүй-ёс зүй-гоо зүй” сэдэвт сургалт
- Шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалт
- Төрийн албан хаагчийн ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ сахин мөрдөх
- Албан хаагчдын дунд ерөнхий мэдлэг шалгах сорил
- Авлигатай тэмцэх газраас Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт
- “Хүндэлье-Энэрье” танин мэдэхүйн АХА
- Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэг

АЛБАН ХААГЧДЫН 70% ЕРӨНХИЙ МЭДЛЭГ ШАЛГАХ СУДАЛГААНД ХАМРАГДЛАА				
№	Асуулт	Хамрагдсан албан хаагчийн тоо	Зөв хариулсан албан хаагч	
			тоо	хувь
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэдэн онд батлагдсан бэ?	69	46	66.7
2	Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэхдээ ямар зүйлд тулгуурладаг вэ?	69	46	66.7
3	Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах гэдгийг Авлигын эсрэг хуульд хэрхэн тодорхойлсон бэ?	69	36	52.2
4	Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг хэрхэн хамгаалах вэ?	69	26	37.7
5	Өргөдөл, гомдлын хянан үзэхгүй байх, буцаах нөхцөлд аль нь хамаарахгүй вэ?	69	40	58

Дүгнэлт: Дээрх судалгааны нэгдсэн дүнгээр байгууллагын албан хаагчдад 2 төрлийн сургалтыг зохион байгуулж авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.



Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа дараах ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ сахин мөрднө:

1. Ард түмэндээ чин сэтгэлтэй үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх;
2. Зан хариуцаж, үз, үйлдэлээр хуний эрх, эрх чөлөө, нэр төр, ахуйг хүндэтгэн, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
3. Хууль ёс, шударга ёсыг бодолд сэтгэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангижрах;
4. Албан үүрэгээ гүйцэтгэхдээ зориулсан өөрийн бүрхүүл үйлдэл, эс үйлдэхүйн шийдэл ёс зүйн хариуцааг хууль ёс байдлыг баримтлах;
5. Төрийн хэм хэмжээг төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчид хамтран мөрдөж, хамтран мөрдөж, хамтран мөрдөж;
6. Төрийн албан хаагчийн хувийн амьдрал, хувийн эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хууль ёсоор баримтлах;
7. Албан үүрэгээ гүйцэтгэхдээ бусад албан хаагчаар дамжин үзүүлэхгүй байх, албаарлан задруулахгүй байх;
8. Байгууллагын соёл, дэг журмыг, албан хариуцааг ёс зүйг чанд сэтгэх, улсын болон байгууллагын нэр хүндийг хамгаалах үйлдэл гэрээгүй байх, олон нийтийн үзлээр эсэргэц, манлайлал үзүүлэх;
9. Албан үүрэгээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хувьд байгаа өрөөнд үзүүлэх нөлөөллийг хамгаалах;
10. Багаар ажиглах, сурацлах, шинэ санаачлыг дэмжих, хамт ажиллагааг эрхэмлэх, удирдах албан тушаалтныг туслахыг дэмжих;

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль. Хоёрдугаар бүтэц. 7 дугаар зүйл.

ДЭД ХОРООНЫ ГИШҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ

- Авлигаас ангид төрийн алба анхан шатны цахим сургалт
- Авлигын эсрэг СУРГАГЧ БАГШ бэлтгэх танхимын сургалт

